

**АМАР**®  
ДААТГАЛ

20  
25

ЖИЛИЙН  
ТАЙЛАН



ISO/IEC 27001:2022



# АГУУЛГА

## ЭРХЭМ ЗОРИЛГО

04

Алсын хараа  
Үнэт зүйлс

## ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН МЭНДЧИЛГЭЭ

05

## БИЗНЕСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

07

Эрсдэлд суурилсан хөрөнгийн хүрэлцээт байдал  
Нийт хөрөнгө  
Даатгалын хураамжийн орлого  
Нийт хураамжийн орлогын бүтэц  
Нөхөн төлбөр  
Үйл ажиллагааны зардал  
Хөрөнгө оруулалт  
Даатгагчийн баталгаа  
Хосолсон харьцаа  
Ашигт ажиллагаа  
Өөрийн хөрөнгийн өгөөж  
Андеррайтингийн эрсдэл  
Байгаль орчин, нийгэм, засаглалын тайлан  
Нийгмийн хариуцлагын хүрээнд хэрэгжүүлсэн ажил

## ДАВХАР ДААТГАЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

23

Давхар даатгалын бодлого  
Багцын давхар даатгал  
Факультатив давхар даатгал  
Хамтран ажилладаг давхар даатгагчид болон брокерууд

## КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

28

Компанийн засаглалын бүтэц  
Төлөөлөн удирдах зөвлөл  
Удирдлагын баг

## ОЛОН УЛСЫН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН ORSA ХӨТӨЛБӨР

33

Санхүүгийн голлох үзүүлэлт

## АУДИТААР БАТАЛГААЖСАН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

37

Аудитаар баталгаажсан санхүүгийн тайлан

# ЭРХЭМ ЗОРИЛГО

Мэргэжлийн ёс зүй, мэргэшсэн үйлчилгээ, тэргүүлэгч инновацыг нэвтрүүлэн эерэг, хялбар, оновчтой даатгалын үйлчилгээг хэрэглэгчдэдээ хүргэж, эрсдэлээс хамгаалагдсан ирээдүйг цогцлооход хувь нэмрээ оруулан хамтдаа үнэт зүйл бүтээн хөгжих нь бидний эрхэм зорилго.

# АЛСЫН ХАРАА

Хүн төрөлхтний нийтлэг үнэт зүйлийг сахин хамгаалж, хүн төвтэй, мэргэжлийн ёс зүйг эрхэмлэсэн олон улсын даатгалын байгууллага болно.

# ҮНЭТ ЗҮЙЛС

**Нэгдэл** – Аливаа байгууллага, хувь хүний эрсдэл нь даатгуулсан өдрөөсөө эхлэн зөвхөн даатгуулагчид бус Амар даатгал, түүний бүх харилцагчид хамааралтай болдог. Нэг нэгнээ эрсдэлээс хамгаалахаар нэгдсэн энэ нэгдэл нь бидний хамгийн чухал үнэт зүйл.

**Итгэл** - Ирээдүйд тохиолдох эрсдэлээс хамгаална хэмээн бидэнд хүлээлгэсэн даатгуулагчдын итгэл, хариуцлага бол даатгалын компанийн оршин тогтнох үндэс.

**Түншлэл** – Бид зөвхөн эрсдэл учирсан хойно нөхөн төлбөр олгох бус, даатгуулагчдадаа хамгийн үр ашигтай даатгалын хувилбарыг сонгож, эрсдэлээ зөв удирдахад нь байнга дэмжлэг үзүүлэх хамтрагч, зөвлөгч нь байна.

**Инновац** - Бид илүү үр өгөөж, эерэг өөрчлөлт авчрах технологийн дэвшил, шинэлэг шийдлүүдийг үргэлж эрэлхийлж, үйл ажиллагаандаа хэрэгжүүлэхийг эрмэлзэнэ.

**Үр өгөөж** - Бидэнд зөвхөн бизнесийн ашиг бус, явуулж буй үйл ажиллагааны маань нийгэмд үзүүлэх үр өгөөж үнэ цэнтэй. Иймээс бид ойрын ашгаас илүү урт хугацааны зорилт, хамтын хөгжлийг тэргүүнд тавьж ажиллана.



## Эрхэм харилцагчид, түншүүддээ,

Та бүхний бидэнд үзүүлсэн итгэл, хамтын ажиллагаанд гүн талархал илэрхийлье.

Амар Даатгал ХХК-ийн хувьд 2025 он нь тогтвортой өсөлт, бодит үр дүн, үнэ цэнийг эрхэмлэсэн он байлаа. Бид та бүхний итгэл, хамтын ажиллагаанд тулгуурлан эрсдэлийн хамгаалалтыг найдвартай хүргэж, санхүүгийн тогтвортой байдлыг бэхжүүлэн нийт 60,000 харилцагчтай хамтран ажиллаж, 24,9 тэрбум төгрөгийн даатгалын хураамж төвлөрүүлэн, гэнэтийн эрсдэлтэй тулгарсан 8,000 орчим харилцагчид нөхөн төлбөр олгож, хүлээсэн үүргээ нэр төртэйгөөр биелүүллээ.

2025 онд компанийн хөрөнгийн хүрэлцээт байдал 287 хувьд хүрч, төлбөр гүйцэтгэх чадвар нь Санхүүгийн Зохицуулах Хорооноос тогтоосон шаардлагыг бүрэн ханган, зах зээл дэх найдвартай, тогтвортой даатгагчийн байр сууриа дахин бататгав. Энэхүү амжилт нь ажиллагсад, түнш байгууллагууд, төлөөлөгчид болон давхар даатгагчидтайгаа харилцан итгэлцэлд суурилсан, үр дүнтэй хамтын ажиллагаа өрнүүлсний бодит илэрхийлэл юм.

Бид байгууллагын засаглал, ил тод байдал, хариуцлагатай удирдлагын тогтолцоог тасралтгүй сайжруулж, олон улсын жишигт нийцсэн Байгаль орчин, нийгэм, засаглал (БОНЗ)-ын бодлого, стандарт, удирдамжийг үйл ажиллагаандаа үе шаттайгаар нэвтрүүлэн, ногоон оффисын бодлого хэрэгжүүлэх, цахим үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх ажлыг өргөжүүлж байна. Мөн уур амьсгалын өөрчлөлт, цөлжилтийн эсрэг чиглэсэн санаачилга, төсөл хөтөлбөрүүдийг дэмжин ажиллаж байгаа нь бидний нийгмийн өмнө хүлээсэн хариуцлагын салшгүй хэсэг билээ.

Нийгмийн хариуцлагын хүрээнд бид ажилтнуудынхаа хөгжлийг дэмжих, мэргэжлийн үр чадварыг тасралтгүй дээшлүүлэх, аюулгүй, тогтвортой ажлын орчныг бүрдүүлэхэд онцгойлон анхаарч, харилцагч төвтэй соёлыг байгууллагын үнэт зүйл болгосоор байна.

Мөн 2025 онд харилцагчийн мэдээллийн нууцлалыг хамгаалах зорилгоор олон улсын ISO/IEC 27001:2022 мэдээллийн аюулгүй байдлын стандартыг бүрэн нэвтрүүлж, мэдээллийн аюулгүй байдлын удирдлагын тогтолцоог бэхжүүллээ.

Цаашид бид сонирхогч талуудынхаа итгэлийг улам бататгаж, тогтвортой өсөлтийг бий болгохын зэрэгцээ нийгэм, эдийн засаг, байгаль орчинд эерэг нөлөө үзүүлэх бодит алхмуудыг тууштай хэрэгжүүлэх болно.

Та бүхний үнэтэй дэмжлэг, хамтын ажиллагаанд дахин талархал илэрхийлж, цаашдын амжилтаа хамтдаа бүтээхийг хүсэн ерөөе.

Хүндэтгэсэн

Гүйцэтгэх захирал

**Батдэлгэрийн Хишигтөр**




БИЗНЕСИЙН  
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

# Эрсдэлд суурилсан хөрөнгийн хүрэлцээт байдал

Санхүүгийн Зохицуулах хорооноос Даатгалын компанийн төлбөрийн чадварыг Эрсдэлд суурилсан хөрөнгийн хүрэлцээт байдлын харьцаагаар тодорхойлох бодлогын өөрчлөлтийг хийж, Олон улсын жишиг Solvency II-ийг даатгалын зах зээлийн зохицуулалтад нэвтрүүлж даатгалын компанийн төлбөрийн чадварыг тоо болон чанарын үзүүлэлтүүдийн хүрээнд авч үздэг бөгөөд компанийн онцлог, цар хүрээ, эрсдэлийн удирдлагын бодлогоос хамааран төлбөрийн чадварыг 5 түвшинд байхаар тодорхойлсон.


## Хөрөнгийн хүрэлцээт байдал, хувиар

Дээрх бодлогын өөрчлөлтөөр даатгалын компанийн Хөрөнгийн хүрэлцээт байдлын байвал зохих хамгийн доод харьцааг 122 хувь байхаар тогтоож өгсөн байдаг ба Амар Даатгал компанийн хувьд дээрх үзүүлэлт 2025 онд 287 хувьтай гарчээ. Энэ нь өмнөх оны мөн үеэс даруй 65 пунктээр сайжирсан байна.



Түүнчлэн, дээрх бодлогын шинэчлэл хэрэгжиж эхэлснээс хойш Амар Даатгал төлбөрийн чадварын түвшин Хамгийн сайн буюу 1 дүгээр ангиллын шаардлагыг тогтмол хангаж байна.

## Төлбөрийн чадварын түвшин ангилал




# Нийт хөрөнгө

Амар Даатгал компанийн нийт хөрөнгө 2024 онд 30.7 тэрбум төгрөг байсан бол 2025 онд 30.8 тэрбум төгрөгт хүрч, 0.3 хувиар өссөн байна. Энэхүү өсөлтөд хөрөнгө оруулалтын хэмжээ 2.4 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн нь голлох нөлөөг үзүүлсэн байна.

Амар Даатгал компанийн 2025 оны нийт хөрөнгийн 6.8 хувийг бэлэн мөнгө болон харилцах, 8.9 хувийг даатгалын хураамжийн авлага, 69.3 хувийг хөрөнгө оруулалт, 1.4 хувийг үндсэн хөрөнгө, программ хангамж эзэлж байна.

## Нийт хөрөнгө, тэрбум төгрөг



# 30.8

тэрбум төгрөг


# Даатгалын хураамжийн орлого

Амар Даатгал компани 2025 онд нийт 24.9 тэрбум төгрөгийн хураамжийн орлого төвлөрүүлж, үүнээс цэвэр хураамжийн орлогоо 20.6 тэрбум төгрөгт хүргэсэн байна. Цэвэр хураамжийн орлого нь өмнөх оноос 27.9 хувиар өссөн нь компанийн орлогын өсөлт тогтвортой нэмэгдэж буйг харуулж байна.


Бид 2025 онд харилцагч төвтэй байх зарчмыг хэрэгжүүлж ажилласан бөгөөд харилцагчийн халамжийн цогц бодлого, харилцагчийн харилцааны удирдлагын системээ илүү боловсронгуй болгон хөгжүүлсэн. Түүнчлэн даатгалын гэрээ байгуулсны дараах харилцагчид зориулсан үйлчилгээг илүү тодорхой, ойлгомжтой болгож, цаашлаад даатгуулагчийн эрсдэлийг бууруулах зөвлөх үйлчилгээг нэвтрүүллээ. Мөн 2025 онд даатгуулагчийн хохирол, нөхөн төлбөрийг түргэн шуурхай, амар хялбараар шийдвэрлэх процессыг хөгжүүлэн ажиллав.

Энэ нь бидэнтэй урт хугацаанд хамтран ажиллах даатгуулагчийн итгэлийг нэмэгдүүлж, харилцагчийн тоо нэмэгдэж даатгалын хураамжийн орлогын хэмжээг өсгөсөн байна. Даатгалын хураамжийн орлогын бүтцийг авч үзвэл 2025 онд нийт 44 төрлийн даатгалын бүтээгдэхүүнийг зах зээлд борлуулж, бүтээгдэхүүний нэр төрөл, хамрах хүрээг өргөжүүлсэн байна. Ингэснээр тодорхой нэг бүтээгдэхүүнээс хэт хамаарах эрсдэлийг бууруулан, эрсдэлийг тархаан байршуулж чадсан нь компанийн тогтвортой өсөлтийг хангах чухал хүчин зүйл болсон байна.


## Нийт хураамжийн орлого, тэрбум төгрөг



## Цэвэр хураамжийн орлого, тэрбум төгрөг



# Нийт хураамжийн орлогын бүтэц, Бүтээгдэхүүнээр



# Нөхөн төлбөр


Амар Даатгал компани эрсдэлийн удирдлагын хүрээнд харилцагчдаас төвлөрүүлсэн хураамжийн дийлэнх хэсгийг олон улсын давхар даатгалын зах зээлд байршуулан, компанийн эрсдэл даах чадавхыг өсгөж, нөхөн төлбөр төлөх баталгааг хангаж ажиллалаа. Энэ бодлого нь компанийн санхүүгийн тогтвортой байдлыг хангахад чухал үүрэг гүйцэтгэдэг.

2025 онд Амар Даатгал нь нийт 7,907 харилцагчид 7.6 тэрбум төгрөгийн даатгалын нөхөн төлбөр олгож, харилцагчдын санхүүгийн эрсдэлийг бууруулан, итгэл найдвартай хамгаалалтыг үзүүлэн ажиллалаа.

Тус онд 23 нэр төрлийн даатгалын бүтээгдэхүүний 8.464 удаагийн нөхөн төлбөрийн нэхэмжлэл хүлээн авсан бөгөөд үүнээс 8.262 нэхэмжлэлийг шийдвэрлэсэн нь нийт нөхөн төлбөрийн тохиолдлын 97 хувийг эзэлж байна.

Дундаж нөхөн төлбөрийн нэхэмжлэлийг шийдвэрлэхэд 4.1 өдрийг зарцуулж ажилласан байна. 2024 онд олгосон нөхөн төлбөрийн хэмжээ 5.4 тэрбум төгрөг байсан бол 2025 онд 7.6 тэрбум төгрөг болж 46.3 хувиар өссөн. Энэ өсөлтөд голлох нөлөөлсөн хүчин зүйлс нь харилцагчдын тоон өсөлт, дундаж нөхөн төлбөрийн өсөлт (жишээлбэл, тээврийн хэрэгслийн сэлбэг хэрэгсэл, засвар үйлчилгээ, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний үнэ тарифын өсөлт) байжээ.

## Нийт нөхөн төлбөр, тэрбум төгрөг



**7.6**  
тэрбум төгрөг


## Үйл ажиллагааны зардал

Амар Даатгал компани 2025 онд даатгалын гэрээ байгуулахтай холбоотой шууд зардал 4.5 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үеэс 32 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Энэ өсөлт нь даатгалын гэрээ болон даатгуулагчийн тоо хурдацтай нэмэгдсэнтэй шууд холбоотой байна.


Түүнчлэн, даатгалын зуучлалын сүвгийн тэлэлт, хамтран ажилладаг байгууллагуудаас орж буй хураамжийн орлого өсөж, түүнтэй холбоотой зардлууд нэмэгдсэн.

Үйл ажиллагааны зардал 3.2 тэрбум төгрөг болж, 52 хувиар өссөн нь үйл ажиллагааны өргөжилт, шинээр нээлттэй ажлын байр, цалин урамшууллын шинэ бодлого хэрэгжүүлсэнтэй холбоотой байна.

## Даатгалын гэрээний зардал, тэрбум төгрөг



## Үйл ажиллагааны зардал, тэрбум төгрөг



# Хөрөнгө оруулалт

Амар Даатгал компани хөрөнгө оруулалтын багцыг үр ашигтай удирдан, эрсдэлийг нарийвчлалтайгаар хянаж ажилладаг. Компанийн хөрөнгө оруулалтын удирдлага нь өдөр бүр тогтмол хяналт тавьж, оновчтой шийдвэрүүдийг гаргаж, компанийн хөрөнгийн эрсдэл болон өгөөжийг тэнцвэртэй байлгахад анхаардаг.

2025 онд компанийн хөрөнгө оруулалтын багц 21.3 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оноос 12 хувиар өссөн. Тайлант хугацаанд 3.4 тэрбум төгрөгийн өгөөж бий болж, хөрөнгө оруулалтын багц 16.7 хувийн өгөөжтэй ажилласан байна.

Хөрөнгө оруулалтын  
багц

**21.3 тэрбум**  
2025 он

**12%**

2024 онтой харьцуулсан өсөлт


Хөрөнгө оруулалтын  
өгөөж

**3.4 тэрбум**  
2025 он

**16.7%**

Хөрөнгө оруулалтын багцын өгөөж

Хөрөнгө оруулалтын багц, тэрбум төгрөг



**21.3**  
тэрбум төгрөг


# Даатгагчийн баталгаа

Монгол Улсын Их хурлаас Даатгалын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай зэрэг хуульд нэмэлт өөрчлөлт оруулж даатгалын компани 4 төрлийн баталгаа, батлан даалт гаргах боломжтой болсон.

Уг хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор Санхүүгийн Зохицуулах хорооноос Даатгагчийн баталгаа гаргах үйл ажиллагааны журмыг баталж мөрдүүлж эхэлсний дагуу Даатгалын компаниуд нь Үндэсний Давхар даатгал компанийн дэргэд "Баталгааны хамтын эрсдэлийн сан" байгуулж, баталгааны нэгдсэн мэдээллийн сан, дүрэм, баталгааны хувь хэмжээг тогтоон ажиллаж байна.

Амар Даатгал нь холбогдох хууль тогтоомж, журмын хүрээнд 2025 онд давхардсан тоогоор 100 гаруй аж ахуйн нэгжид нийт 10 орчим тэрбум төгрөгийн тендерийн баталгаа, урьдчилгаа төлбөрийн баталгаа, гүйцэтгэлийн баталгаа гарган ажилласан. Ингэснээр баталгаа гаргуулсан харилцагчид банканд 10 тэрбум төгрөгийн мөнгөн хөрөнгийг тодорхой хугацаагаар түгжих шаардлагаас чөлөөлөгдөж, санхүүгийн хүндрэлээс зайлсхийхээс гадна эргэлтийн хөрөнгөө үйл ажиллагаандаа үр ашигтайгаар ашиглах боломж бүрдсэн.

**10**  
тэрбум төгрөг




## Хосолсон харьцаа

Даатгалын компанийн үйл ажиллагааны тогтвортой байдлыг илэрхийлэх гол үзүүлэлтүүдийн нэг нь даатгалын хосолсон харьцаа байдаг. Энэ нь орлогод тооцсон хураамжид даатгалын гэрээний зардал, үйл ажиллагааны зардал, нөхөн төлбөрийн зардлын нийлбэрийг харьцуулан тооцдог үзүүлэлт юм.

2025 онд Амар Даатгал компанийн хосолсон харьцаа 91% болсон нь компанийн эрсдэлийн удирдлага, андеррайтингийн зөв бодлого, мөн зардлыг бууруулах чиглэлд хийсэн хөрөнгө оруулалтын үр дүн юм.

### Хосолсон харьцаа, хувиар




# Ашигт ажиллагаа

Амар Даатгал компани 2025 онд татварын дараах цэвэр ашгаа өмнөх оноос 67.5 хувиар өсгөж 5.6 тэрбум төгрөгт хүргэж ашигт ажиллагааны өндөр өсөлттэй ажиллалаа. 2025 онд даатгалын цэвэр хураамжийн орлогоо өсгөж, мөн Олон Улсын давхар даатгалын зах зээлээс комиссын орлого олсон нь ашигт ажиллагааны өсөлтөд гол нөлөө үзүүлсэн.


Түүнчлэн компанийн удирдлагын баг үйл ажиллагааны зохистой удирдлагын бодлогыг хэрэгжүүлж, зардлыг тогтвортой барьж, цаашлаад хөрөнгө оруулалтын багцаа өсгөсөн нь дээрх өсөлтийг бий болгох нөхцөлийг бүрдүүлжээ.

## Татварын дараах цэвэр ашиг, тэрбум төгрөг



Амар Даатгал нь 2025 онд ашигт ажиллагааны гол үзүүлэлт болох Өөрийн Хөрөнгийн Өгөөж (ROE)-ийг 35.8 хувьд хүргэж чаджээ. Энэ даатгалын салбарын дундаж хувиас 2.1 дахин өндөр үзүүлэлт юм.

## Өөрийн хөрөнгийн өгөөж, хувиар



# АНДЕРРАЙТИНГИЙН ЭРСДЭЛ

Амар Даатгал компани даатгалын бүтээгдэхүүн бүрийн эрсдэлийг кодчилж, андеррайтингийн цэвэр эрсдэлийг улирал бүрээр тооцоолж, харилцагч, даатгуулагч бүрийн онцлогт тохирсон даатгалын хамгаалалт санал болгох стратегийг хэрэгжүүлдэг бөгөөд энэ стратегийн хүрээнд харилцагч, даатгуулагчдын хэрэгцээ шаардлагад нийцсэн түгээмэл даатгалын бүтээгдэхүүнүүдийн эрсдэлийг кодчилж андеррайтингийн эрсдэлийг тооцоолж ажиллалаа.

AmarCare эрүүл мэндийн даатгалын бүтээгдэхүүнийг Олон улсын эрүүл мэндийн ICD код болон эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүснэгттэй уялдуулан кодчилсон нь харилцагч, даатгуулагчийн өвчлөл, эрсдэлийг бүрэн таних, эрсдэлийн үнэлгээ хийх, даатгалын гэрээг дүгнэх, даатгуулагч бүрд тохирох эрүүл мэндийн тусламж үйлчилгээний багцыг санал болгох боломжийг улам бататгаж байна.

Харилцагчийн зан төлөвийн нарийвчилсан судалгаанд үндэслэн зах зээлийн эрэлт, хэрэгцээ, хүлээлтийг тодорхойлж, уг мэдээлэлд тулгуурлан шинэ бүтээгдэхүүн боловсрууллаа. Мөн даатгалын зүйлийн онцлог, эрсдэлийн үнэлгээ, хэрэглэгчийн сегментэд нийцүүлсэн судалгаа, шинжилгээг тухай бүр гүйцэтгэх аргачлал, үйл явцыг боловсронгуй болгож, бүтээгдэхүүний загварчлал, үнэлгээ, нөхцөлийг цогцоор нь шинэчлэн сайжрууллаа.





БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ,  
ЗАСАГЛАЛЫН ТАЙЛАН



## Байгаль орчин, нийгэм, засаглал

Бид Монгол Улсын "Алсын хараа 2050" болон бусад урт хугацааны бодлого, зорилтуудыг хэрэгжүүлэхэд хувь нэмрээ оруулах зорилттойгоор бизнесийн үйл ажиллагаагаа НҮБ-ын Тогтвортой хөгжлийн зорилго, зорилтуудтай уялдуулан байгаль орчин, нийгэм, засаглал (БОНЗ)-ын тогтолцоог үе шаттайгаар нэвтрүүлэн хэрэгжүүлж байна.

Олон улсын жишигт нийцсэн БОНЗ тогтвортой байдлын бодлого, стандарт, удирдамжийг даатгалын үйл ажиллагаанд нэвтрүүлснээр бид эрсдэлийн үнэлгээ, андеррайтинг, хөрөнгө оруулалтын шийдвэр гаргалтад БОНЗ хүчин зүйлийг системтэй тусгах боломж бүрдэнэ. Ингэснээр:

- Даатгалын эрсдэлийг илүү нарийвчлалтай тодорхойлох, урьдчилан сэргийлэх чадамж сайжирна.
- Үүр амьсгалын өөрчлөлт, байгаль орчны болон нийгмийн эрсдэлийн нөлөөллийг тооцсон бүтээгдэхүүн, үйлчилгээ хөгжүүлэх нөхцөл бүрдэнэ.
- Хөрөнгө оруулалтын багцын тогтвортой байдал, урт хугацааны өгөөж нэмэгдэнэ.
- Харилцагч, давхар даатгагч болон хөрөнгө оруулагчдын итгэлцэл бэхжинэ.

Товчоор хэлбэл, БОНЗ-д суурилсан удирдлага нь даатгалын салбарын санхүүгийн тогтвортой байдлыг хамгаалахаас гадна урт хугацааны үнэ цэнийг бий болгох стратегийн чухал хэрэгсэл юм.

Хуванцар хаягдлын менежментийг сайжруулах, 10 жилийн сургуулийн хүүхдүүдийн дунд байгаль орчны мэдлэгийг дээшлүүлэх зорилтын хүрээнд TML Plastic ХХК хамтран "Та ч бас дахин боловсруулж чадна" аянг Нийслэлийн ерөнхий боловсролын сургуулиудын дунд амжилттай зохион байгууллаа



# Цаасгүй оффис - CO<sub>2</sub> ялгарлыг бууруулах

Амар Даатгал компани нь үйл ажиллагаандаа цахим шийдлийг нэвтрүүлснээр 4,800 удаагийн нөхөн төлбөрийг цахимаар шийдвэрлэсэн байна. Үүний үр дүнд цаасны хэрэглээг мэдэгдэхүйц бууруулж, байгаль орчинд ээлтэй үйл ажиллагааг хэрэгжүүллээ. Тооцооллоор дундаж нэг нарс модноос 10,000–15,000 хуудас цаас үйлдвэрлэдэг гэж үзвэл. Цахим шийдэл нэвтрүүлснээр цаасны хэрэглээг 93.3 хувиар бууруулж, байгаль орчинд ээлтэй, нийгмийн хариуцлагатай, засаглалын тогтвортой байдлыг бэхжүүлэх бодит өөрчлөлтийг хэрэгжүүлж байна.

ТА Ч БАС ДАХИН   
БОЛОВСРУУЛЖ ЧАДНА

67,200

Хэмнэсэн цаас

93.3%

Цаасны хэрэглээ буурсан

## Инновац болон дэд бүтцийг хөгжүүлэх

### Мэдээллийн аюулгүй байдал

Бид үйл ажиллагааныхаа чанар, аюулгүй байдлыг олон улсын жишигт нийцүүлэх зорилтын хүрээнд Мэдээллийн аюулгүй байдлын удирдлагын тогтолцооны ISO/IEC 27001:2022 олон улсын стандартыг хэрэгжүүлж бүрэн нэвтрүүллээ.

Тус стандарт нь байгууллагын мэдээллийн нууцлал, бүрэн бүтэн байдал, хүртээмжтэй байдлыг хангах цогц удирдлагын тогтолцоог бүрдүүлэхэд чиглэдэг бөгөөд эрсдэлийг үнэлэх, бууруулах, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг системтэйгээр хэрэгжүүлэх олон улсын шаардлагыг тодорхойлдог.

ISO/IEC 27001:2022 стандартыг нэвтрүүлснээр Амар Даатгал компани нь харилцагч, хамтрагч байгууллагуудын мэдээллийн аюулгүй байдлыг өндөр түвшинд хамгаалах, кибер эрсдэлийг бууруулах, дотоод хяналт, засаглалыг сайжруулах, хууль эрх зүйн шаардлагыг хангах суурь нөхцөлийг бүрдүүлж байна. Цаашид бид мэдээллийн аюулгүй байдлын соёлыг байгууллагын хэмжээнд төлөвшүүлж, олон улсын стандартад нийцсэн тогтолцоог бүрэн хэрэгжүүлэх чиглэлд үе шаттай арга хэмжээг авч ажиллах болно.



ISO/IEC 27001:2022

# Үндэсний Ногоон Лаб


Амар Даатгал компани нь Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар, Монголын Байгалийн Өв Сан, Монголын Бизнесийн Зөвлөл болон бусад түншүүдтэй хамтран байгуулж буй "Үндэсний Ногоон Лаб" хөтөлбөрийг дэмжин ажиллаж байна. Тус хөтөлбөр нь тогтвортой байгалийн менежмент, уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэх, усыг хамгаалах, бэлчээрийн тогтвортой менежмент зэрэг салбарт бодит үр дүнтэй, хэмжигдэхүйц нөлөө бүхий төсөл хэрэгжүүлэхийг дэмжихэд чиглэнэ.

Хөтөлбөрийн нээлт 2026 онд НҮБ-ын Цөлжилттэй тэмцэх тухай конвенцын Талуудын 17-р бага хурал (COP17)-ын хүрээнд зохион байгуулагдах юм.


## Хэнд зориулагдсан бэ ?




Байгальд ээлтэй  
инновацилаг төсөл  
санаачлагч,  
хэрэгжүүлэгчид



Хөрөнгө оруулагч  
донор, санхүүгийн  
байгууллагууд




Төрийн  
байгууллага,  
бодлого  
боловсруулагчид



Судалгаа,  
шинжилгээний  
институт, зөвлөх  
байгууллагууд





НИЙГМИЙН ХАРИУЦЛАГЫН  
ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛСЭН АЖИЛ

# Нийгмийн хариуцлага

Амар Даатгал компани нь нийгмийн хариуцлагын хүрээнд даатгалын бүтээгдэхүүн, үйлчилгээгээр дамжуулан иргэд, байгууллагуудын санхүүгийн эрсдэлийг бууруулах, нийгмийн хамгааллыг дэмжих чиглэлээр бодит үр дүнтэй ажил хэрэгжүүлж байна.

Бид 2025 онд Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ийн ажилтнуудад эрүүл мэнд болон гэнэтийн ослын даатгалын хамгаалалт үзүүлж, даатгуулагчдад учирсан эрсдэлийн нөхөн төлбөрийг шуурхай шийдвэрлэв. Нийт 1 тэрбум гаруй төгрөгийн нөхөн төлбөрийг 5 хоногийн дотор олгосон нь даатгалын үйлчилгээний найдвартай, шуурхай байдлыг бататгасан чухал үзүүлэлт боллоо. Энэхүү үйл ажиллагаа нь гэнэтийн эрсдэлийн үед ажилтнууд болон тэдгээрийн гэр бүлийн санхүүгийн тогтвортой байдлыг хамгаалах, амьдралын чанарт сөргөөр нөлөөлөх эрсдэлийг бууруулахад бодит хувь нэмэр оруулж байна.

Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ нь ажилтнуудынхаа эрүүл мэнд, гэнэтийн ослын эрсдлээс хамгаалах даатгалын хөтөлбөрийг түүчээлэн хэрэгжүүлж байгаа нь бусад төрийн байгууллагад жишиг болохуйц онцлогтой үйл ажиллагаа боллоо.

Мөн Амар Даатгал компани нь даатгалын үйлчилгээг илүү хүртээмжтэй болгох зорилгоор цахим үйлчилгээ, онлайн даатгалын системийг нэвтрүүлж, уян хатан төлбөрийн нөхцөлүүдийг санал болгож байна. Ингэснээр харилцагчид байршил, цаг хугацааны хязгаарлалтгүйгээр даатгалд хамрагдах боломж бүрдсэн бөгөөд үйлчилгээний хурд, ил тод байдал нэмэгдлээ. Даатгалын бүтээгдэхүүнээр дамжуулан санхүүгийн эрсдэлийг бууруулах, нийгмийн хамгааллыг дэмжих нь компанийн тогтвортой хөгжлийн бодлогын салшгүй хэсэг бөгөөд бид цаашид даатгалын хүртээмжийг нэмэгдүүлэх, дижитал шийдлүүдийг өргөжүүлэх, нийгмийн хамгаалалд чиглэсэн шинэ бүтээгдэхүүн хөгжүүлэх чиглэлээр үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.

Амар Даатгал компани нь 2025 онд Шанхын Баруун хүрээ хийдийн түүхэн уламжлал, соёлын өвийг хадгалж хамгаалах, олон нийтэд түгээн дэлгэрүүлэх эрхэм үйлсийг дэмжиж, үнэт өв соёлыг хойч үедээ өвлүүлэн үлдээхэд хувь нэмэр оруулан нийгмийн хариуцлагын хүрээнд дэмжлэг үзүүлэн хамтран ажиллалаа.





## Хамтын ажиллагаа

Монгол - Вьетнамын дипломат харилцаа тогтоосны 70 жилийн ой 2025 онд тохиож буйтай холбогдуулан, их зохиолч Ч.Лодойдамбын "Тунгалаг Тамир" романыг тусгайлан 70 ширхгийг Вьетнам хэл дээр Hanoi Re компанигай хамтран хэвлүүлж нээлтийг Ханой хотод хийлээ. Тус роман социализмын үед Вьетнамын дунд сургуульд заавал унших 10 номын нэг байсан түүхтэй аж.

# Санхүүгийн хүртээмж

Энэ жил бид салбартаа түүчээлэн технологи, мэдээллийн шинэ системүүдийг ашиглаж, хурдан, найдвартай үйлчилгээ үзүүлэх, даатгуулагчдын сэтгэл ханамжийг дээшлүүлэхэд онцгой анхааран малчдад зориулсан амь насны даатгалын үйлчилгээг нэвтрүүлж даатгалын үйлчилгээг тогтвортой, хүртээмжтэй байдлаар хүргэхээр Зээлийн батлан даалтын сантай хамтран ажиллаж байна.

Тус үйлчилгээ нэвтэрснээр малчдын амьжиргаа, гэр бүлийн амьдралыг гэнэтийн эрсдэлээс хамгаалах, санхүүгийн баталгааг хангах боломжийг олгодог бөгөөд тэднийг санаа амар аж ахуйгаа төлөвлөн, ирээдүйд хөрөнгө оруулалт хийхэд дэмжлэг үзүүлнэ.





ДАВХАР ДААТГАЛЫН  
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

# Давхар даатгалын бодлого

Амар Даатгал компанийн эрсдэлийн удирдлагын чадавхыг нэмэгдүүлэх, даатгалын үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангах зорилгоор Монгол Улсын бизнесийн цар хүрээ, эрсдэлийн хэмжээнд нийцсэн, "A.M. BEST" компанийн зэрэглэлтэй, Lloyd-н зах зээл дээр хүлээн зөвшөөрөгдсөн Олон улсын давхар даатгагчид, брокеруудтай шууд харилцан хамтарч, эрсдэлээ хуваан байршуулж ажиллаж байна.

Бидний давхар даатгалын стратеги нь компанийн эрсдэлийн чадавхад тохирсон Багцын давхар даатгалын хамгаалалт авч, тухайн хамгаалалтаас давсан нөхцөлд Факультатив давхар даатгалын бизнесийг хөгжүүлэн ажиллаж байна.

## Багцын давхар даатгал

Нэг удаагийн гэнэтийн томоохон эрсдэлээс хамгаалах, тогтвортой байдлыг хангах зорилгоор багцын давхар даатгалын хамгаалалтыг тогтмол хэрэгжүүлдэг. Бид жил бүр эрсдэл даах чадамж болон багцын нарийвчилсан шинжилгээ хийсний үндсэн дээр даатгалын бүтээгдэхүүнүүдийн хамгаалалтын хүрээ, бүтэц, хэмжээг тодорхойлж шийдвэр гаргадаг.

Түүнчлэн дотоодын даатгалын зах зээлийн хөгжлийг дэмжих, хөрөнгийн эргэлтийг нэмэгдүүлэх зорилгоор "Үндэсний Давхар Даатгал" ХК-тай стратегийн хамтын ажиллагааг өргөжүүлэн ажиллаж байна. Энэхүү хамтын ажиллагааны хүрээнд бид трити буюу багцын давхар даатгалын хамгаалалтыг Үндэсний Давхар Даатгал ХК-аар дамжуулан гэрээлж, Францын давхар даатгалын компани Scor Re-ээс авч ажилласаар байна.

Харин 2025 оноос эхлэн эрсдэлээ олон улсын түвшинд илүү өргөн хүрээнд, тэнцвэртэйгээр байршуулах зорилгоор S&P Global үнэлгээний агентлагаас AA үнэлгээтэй Singapore Reinsurance Corporation Limited компанид багцын давхар даатгалын хамгаалалтын тодорхой хувийг шилжүүлэн хамтран ажиллаж байна. Ингэснээр бид "Үндэсний Давхар Даатгал" ХК-тай хэрэгжүүлж ирсэн хамтын ажиллагаагаа хэвээр хадгалан үргэлжлүүлэхийн зэрэгцээ Азийн зах зээл дэх олон улсын түншүүдийн сүлжээгээ тэлж, эрсдэлийн тархалтыг илүү оновчтой болгож байгаа юм.

**SCOR** A+ (Strong)  
The Art & Science of Risk



AA+ (Strong)

**Mongolian Re** B+ (Good)

## Трити буюу багцын давхар даатгалын хамгаалалт:

БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ТӨРӨЛ	/ТӨГРӨГӨӨР/
Хөрөнгийн даатгал болон түүнийг дагасан бараа материал, тоног төхөөрөмж, бизнес тасалдлын даатгал	10,000,000,000
Барилга угсралтын ажлын иж бүрэн даатгал	10,000,000,000
Хүнд болон тусгай зориулалтын машин механизм	7,000,000,000
Хүнд даацын тээврийн хэрэгслийн даатгал	7,000,000,000
Гадаад болон дотоод ачаа тээврийн даатгал	5,000,000,000
Байгууллагын ерөнхий хариуцлагын даатгал, Бүтээгдэхүүний хариуцлагын даатгал, Ажил олгогчийн хариуцлагын даатгал, Мэргэжлийн хариуцлагын даатгал	5,000,000,000
Тээврийн хэрэгслийн даатгал /Вангиллын/	2,800,000,000

## Факультатив давхар даатгал

Амар Даатгал компани факультатив давхар даатгалын чиглэлээр олон улсын "А" болон түүнээс дээш үнэлгээтэй, дэлхийд тэргүүлэгч, нэр хүнд бүхий давхар даатгагчидтай тогтвортой хамтран ажиллаж, эрсдэлийг олон улсын зах зээлд оновчтой хуваан байршуулах стратегийг хэрэгжүүлж байна. Манай түншүүд нь дэлхийн давхар даатгалын зах зээлд тэргүүлэх байр суурь эзэлдэг томоохон давхар даатгагчид бөгөөд хамтын ажиллагааны хүрээнд бид андеррайтингийн зөвлөх үйлчилгээг авч, олон улсын түвшинд хүлээн зөвшөөрөгдсөн түршлага, мэдлэгийг үйл ажиллагаандаа нэвтрүүлснээр мэргэжлийн чадавхаа тогтвортойгоор бэхжүүлэн ажиллаж байна.

Факультатив давхар даатгалын эрсдэлүүдийн хүрээнд бид олон улсад нэр хүнд бүхий, мэргэшсэн, магадлан итгэмжлэгдсэн тэргүүлэгч давхар даатгалын брокеруудтай хамтран ажиллаж, олон улсын зах зээл дэх хамтын ажиллагааны цар хүрээгээ тогтвортойгоор өргөжүүлж байна.



## Олон улсын эрүүл мэндийн даатгал

Манай компани олон улсын эрүүл мэндийн даатгалын үйлчилгээний хүрээнд Их Британийн "Morgan Price International Healthcare Ltd" компанитай хамтран ажиллаж, иргэд болон байгууллагуудад зориулсан эрүүл мэндийн даатгалын бүтээгдэхүүнүүдийг санал болгож байна.

Энэхүү даатгалын бүтээгдэхүүнийг А.М. Best агентлагийн А+ (Superior) үнэлгээтэй Японы "Sompo International" давхар даатгагчид давхар даатгуулснаар харилцагчдад хамгийн найдвартай хамгаалалтыг санал болгож байна.



## Гадаад аяллын давхар даатгагч болон Third party assistance

Амар Даатгал компани нь SinoAsia B&R Insurance JSC компанийн гадаад зорчигчийн даатгалын бүтээгдэхүүнийг Их Британийн Crossborder Health Partner LTD даатгалын зуучлагчаар дамжуулан, харилцагчдад хүргэн ажиллаж байна. Тус даатгалын бүтээгдэхүүн нь COVID-19 халдварт өвчний эмчилгээ, тусгаарлалтын зардал, мөн спортын бүх төрлийн эрсдэлийг бүрэн хариуцдаг онцлогтой юм.







WHITECAP  
RESOURCES INC.

中国平安  
PING AN  
财险 银行 寿险

SOMPO  
TOKIO MARINE  
IRL

OMAN Re

ALLIED  
WORLD

Hanoi Re  
PVI

SINGAPORE RE




# КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

## Компанийн засаглал

Амар Даатгал компани засаглалын тогтолцоогоо сайжруулах, байгууллагын соёл болон оролцогч талуудын сэтгэл ханамжийг бэхжүүлэх зорилгоор үйл ажиллагаандаа баримтлах засаглал, соёлын суурь баримт бичиг болох Ёс зүйн дүрмийг хэрэгжүүлдэг. Энэ нь компанийн ёс зүйн хэм хэмжээг төлөвшүүлж, хэрэгжилтийг хангахад чиглэгддэг.

Амар Даатгал компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнд 5 гишүүний 2 нь хараат бус гишүүн байна. Энэ нь Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтолцоо нэг талыг баримталсан шийдвэр гаргах эрсдэлийг бууруулж байгааг харуулж байна. Төлөөлөн удирдах зөвлөлийн удирдан чиглүүлэх үндсэн ажлыг гүйцэтгэхэд өндөр хувь нэмэр оруулахуйц санхүүгийн мэргэшсэн мэргэжилтнүүд болон олон улсын эрх бүхий хуульчаар зөвлөлөө бүрэлдүүлсэн. 2025 онд 16 удаа ээлжит болон ээлжит бус байдлаар хуралдаж 35 асуудлыг, Хувьцаа эзэмшигчдийн 2 удаагийн хурлаар 6 асуудлыг шийдвэрлэсэн тогтоол, шийдвэр гаргасан байна.

## Компанийн засаглалын бүтэц



# Төлөөлөн Удирдах Зөвлөл

## П. Золзаяа

ТУЗ-ийн дарга

Хүмүүнлэгийн Ухааны Их Сургуулийн бакалаврын зэрэгтэй. 2008 оноос даатгалын зах зээлд ажлын гараагаа эхэлсэн бөгөөд Кей Эйч Кей ХХК-ийн Гүйцэтгэх захирал, 2019 оноос Амар Даатгал компанийн ТУЗ-ийн даргын албыг хашиж байна.

## Б.Хишигтөр

ТУЗ-ийн гишүүн

БНСУ-ын Сонмун Их сургуулийн Бизнесийн удирдлагын магистрын зэрэгтэй. Банк санхүү, даатгалын салбарт 20 гаруй жил ажилласан бөгөөд байгууллагын даатгалын чиглэлээр мэргэшиж, томоохон байгууллагуудын мега төслүүд дээр даатгагч, эрсдэлийн зөвлөхөөр ажилласан туршлагатай. АНУ-ын American Insurance Corp, Тэнгэр Даатгал ХК, Монгол Даатгал ХК зэрэг байгууллагад ажиллаж байсан. Мөн БНСУ-д ажиллаж буй монгол иргэдэд зориулсан анхны даатгалын үйлчилгээг нэвтрүүлэх төслийг санаачлан хэрэгжүүлсэн. 2023 онд Амар Даатгал компанийн ТУЗ-ийн гишүүнээр томилогдсон.

## Б.Батбаяр

ТУЗ-ийн хараат бус гишүүн

АНУ-Монголын хамтарсан Жи Ти Эс Адвокат ХХН-ийн гишүүн-захирал, АНУ-ын Нью-Йорк хотод төвтэй Firebird Global Master Fund, Ltd хөрөнгө оруулалтын сангийн Монгол улс дахь төслүүдийн хуулийн зөвлөхөөр ажиллаж байсан туршлагатай.

Мөн Novus Law Group LLP хуулийн фирмийг үүсгэн байгуулж, захирлаар ажиллаж байв. 2025 онд Амар Даатгал компанийн ТУЗ-ийн хараат бус гишүүнээр томилогдсон.

## Т.Батзүл

ТУЗ-ийн гишүүн

СЭЗДС-ийн банк, санхүүгийн бакалавр, Люксембургийн Их сургуулийн Санхүүгийн удирдлагын Мастер зэрэгтэй. Тэрээр 2000 оноос Худалдаа хөгжлийн банкнаас ажлын гараагаа эхэлж, 2007 оноос Монгол шуудан банканд ахлах ажилтан, Газрын захирлаар тус тус ажилласан.

Түүнчлэн Миг Даатгал ХХК-д Дэд захирал, Монгол Даатгал ХХК-д Гүйцэтгэх захирал, 2019 оноос 2025 он хүртэл Амар Даатгал ХХК-д Гүйцэтгэх захирал албан тушаал эрхэлж байна. Мөн тэрээр Монголын Даатгалын Холбооны Ерөнхийлөгчийн сонгуульд ажилтай

## Ц.Эрдэнэбат

ТУЗ-ийн хараат бус гишүүн

Сингапур улсад мэдээллийн удирдлагын системч, АНУ-д Бизнесийн удирдлагын бакалавр, Денверийн их сургуульд Олон улсын улс төр, эдийн засаг судлалын магистрын зэрэг хамгаалсан. Тэрээр Монголын хөрөнгийн биржид гадаад харилцааны реферант, Сангийн яаманд Сангийн сайдын туслах, ахлах эдийн засагч, Азийн санд ахлах мэргэжилтэн, НҮБ-д Ази, номхон далайн бүсийн үйлчилгээний мэргэжилтэн, зохицуулагч, АНУ дахь Эксперт консалтинг компанид зөвлөх болон захирлаар ажилласан туршлагатай. 2022 онд Амар Даатгал компанийн ТУЗ-ийн хараат бус гишүүнээр томилогдсон.

# Удирдлагын баг



**Т.Батзүл**  
Ерөнхийлөгч

СЭЗДС-ийн банк, санхүүгийн бакалавр, Люксембургийн Их сургуулийн Санхүүгийн удирдлагын Мастер зэрэгтэй. Тэрээр 2000 оноос Худалдаа хөгжлийн банкнаас ажлын гараагаа эхэлж, 2007 оноос Монгол шуудан банканд ахлах ажилтан, Газрын захирлаар тус тус ажилласан. Түүнчлэн Миг Даатгал ХХК-д Дэд захирал, Монгол Даатгал ХХК-д Гүйцэтгэх захирал, 2019 оноос 2025 он хүртэл Амар Даатгал компанид Гүйцэтгэх захирал албан тушаал эрхэлж байсан. Мөн тэрээр Монголын Даатгалын Холбооны Ерөнхийлөгчийн сонгуульд ажилтай. 2025 оноос Амар Даатгал компанийн Ерөнхийлөгчөөр ажиллаж байна.



**С.Ганчимэг**  
Дэд ерөнхийлөгч

ОХУ-ын Санкт-Петербург хотын СЭЗДС-ийг даатгалын эдийн засагч мэргэжлээр бакалавр зэрэгтэй дүүргэсэн. 2000 оноос хойш Бат даатгал ХХК, Тэнгэр Даатгал ХК, Монгол Даатгал ХК зэрэгт Үйл ажиллагаа хариуцсан захирал, Даатгал эрхэлсэн захирлын албан тушаалд 20 гаруй жил ажилласан туршлагатай, 2019 оноос эхлэн Амар даатгал компанид Даатгал эрхэлсэн захирал, Үйл ажиллагаа эрхэлсэн дэд захирлаар тус тус ажиллаж байна. 2025 оноос Амар Даатгал компанийн Дэд ерөнхийлөгчөөр ажиллаж байна.



**Б.Хишигтөр**  
Гүйцэтгэх захирал

БНСУ-ын Сонмун Их сургуулийн Бизнесийн удирдлагын магистрын зэрэгтэй. Банк санхүү, даатгалын салбарт 20 гаруй жил ажилласан бөгөөд байгууллагын даатгалын чиглэлээр мэргэшиж, томоохон байгууллагуудын мега төслүүд дээр даатгагч, эрсдэлийн зөвлөхөөр ажилласан туршлагатай.

АНУ-ын American Insurance Corp, Тэнгэр Даатгал ХК, Монгол Даатгал ХК зэрэг байгууллагад ажиллаж байсан. Мөн БНСУ-д ажиллаж буй монгол иргэдэд зориулсан анхны даатгалын үйлчилгээг нэвтрүүлэх төслийг санаачлан хэрэгжүүлсэн. 2019 оноос 2024 оны хооронд Амар Даатгал компанийн Дэд захирал албан тушаалыг хашиж, 2025 оноос Гүйцэтгэх захирлаар томилогдон ажиллаж байна.



**Я.Чойжилсүрэн**  
Дэд захирал

Мандах бүртгэл дээд сургууль, МУИС-ийн Хууль зүйн сургуулийг санхүүч, эрх зүйч мэргэжлээр тус тус дүүргэж, 20 гаруй жил санхүүгийн салбарт ажилласан туршлагатай мэргэшсэн санхүүч, аудитор.

2009 онд Гэр даатгал ХХК-д Ерөнхий нягтлан бодогчоор ажиллаж эхэлснээс хойш Гүйцэтгэх захирал, ТУЗ-ийн гишүүн, 2019 оноос Амар Даатгал компанийн Дэд захирлаар ажиллаж байна.

# Удирдлагын баг



## Т.Билгүүн

Нөхөн төлбөрийн газрын захирал

МУИС-ийн Хууль зүйн сургуулийг Эрх зүйч, хуульч мэргэжилтэй дүүргэсэн, Монголын хуульчдын холбооны гишүүн. 2015 оноос Монгол Даатгал ХК-д Тусгай активын ажилтан, Тусгай активын ахлах ажилтан, Ахлах хуульчаар, 2019 оноос Амар Даатгал компанид Үйл ажиллагааны газрын захирал, 2024 оноос Нөхөн төлбөрийн газрын захирлын албан тушаалыг хашиж байна.



## Б.Гэрэлтсүвд

Сувгийн удирдлагын газрын захирал

УБЭИС-ийн Банк санхүүгийн тэнхимийг нягтлан бодогч мэргэжлээр дүүргэн 2018 оноос Монгол Даатгал ХК-д иргэдийн даатгалын менежер, 2019 оноос Амар Даатгал компанийн Маркетинг, харилцагчийн үйлчилгээ хариуцсан менежер, 2023 оноос Сувгийн удирдлагын газрын захирлаар томилогдон ажиллаж байна.



## Д.Уранцэцэг

Эрсдэлийн удирдлагын газрын захирал


МУИС-ийн Математик Компьютерын сургуулийг Хэрэглээний математикч, Бизнесийн сургуулийг Санхүүгийн магистрын зэрэгтэй төгссөн. Их Британий актуарчдын нийгэмлэгийн олон улсын САА /Certified Actuarial Analyst/ Module-ийн 0-4 шалгалтуудад тус тус тэнцсэн. Монгол Улсын урт хугацааны болон ердийн даатгалын Актуарчийн эрхтэй. Актуарчийн нийгэмлэгийн гишүүн. Мэргэжлийн сургагч багш. 2016 оноос Амар Даатгал компанид Актуарч, 2023 оноос Эрсдэлийн удирдлагын газрын захирлаар тус тус ажиллаж байна.



## Г.Энхманлай

Үйл ажиллагааны газрын захирал


МУИС-БС-ийн Бизнесийн менежмент магистрын зэрэгтэй. Хяналтын байгууллага болон уул уурхайн салбарт 15 жил ажилласан бөгөөд хүний нөөц, банк, санхүүгийн хяналт шалгалтын чиглэлээр томоохон хяналтыг хэрэгжүүлж ажилласан туршлагатай. Мобиком корпораци ХХК, Монополын эсрэг газар, Нормаунт ХХК зэрэг байгууллагад ажиллаж байсан. 2025 оноос Амар Даатгал компанийн Үйл ажиллагааны газрын захирлаар томилогдон ажиллаж байна.



ORSA ДААТГАГЧИЙН ЭРСДЭЛ  
БОЛОН ТӨЛБӨРИЙН ЧАДВАР

# ORSA ДААТГАГЧИЙН ЭРСДЭЛ БОЛОН ТӨЛБӨРИЙН ЧАДВАРЫН ҮНЭЛГЭЭНИЙ СИСТЕМ

## ORSA




Бид хууль, эрх зүйн нийцлийн хүрээнд эрсдэлийн удирдлагын ORSA (Own Risk and Solvency Assessment) хөтөлбөр буюу өөрийн эрсдэл болон төлбөрийн чадвараа үнэлэх аргачлалыг хэрэгжүүлэн ажиллаж байна. Энэхүү хөтөлбөр нь бид өөрийн дотоод болон гадаад хүчин зүйл тус бүрээр эрсдэлүүдийг таних, хэмжих, хянах, удирдах цогц аргачлал бөгөөд тухайн даатгалын компанийг бүтнээр нь тольдон харах томруулдаг шил гэж ойлгож болно.

# ORSA ДААТГАГЧИЙН ЭРСДЭЛ БОЛОН ТӨЛБӨРИЙН ЧАДВАРЫН ҮНЭЛГЭЭНИЙ СИСТЕМ

## ORSA-г хэрэгжүүлснээр

Бизнесийн үйл ажиллагаанд учирч болох эрсдэлийн онцлог, цар хүрээ, харилцан хамааралтай шинж чанарыг тодорхойлох хамгийн тохиромжтой аргачлал учраас эрсдэлийн удирдлагын үйл явцыг ил тод болгох, эрсдэлээ хянах болон бууруулахад илүү хялбар болсон. Олон улсын туршлагаар даатгалын компаниуд эрсдэлээ хэрхэн удирдаж байгаагаа даатгуулагчид ил тод тайлагнахыг шаарддаг бөгөөд энэхүү жишгээр Амар Даатгал компани нь ORSA хөтөлбөрийг нэвтрүүлснээр харилцагч, даатгуулагчдынхаа эрсдэлийг хэрхэн авч, удирдаж буйгаа нээлттэй мэдээлж байна. Амар Даатгал компани ORSA Toolkit 1.0.0.2 програмаар эрсдэлийн матрицаа үүсгэн, улирал тутамд тогтмол хөтөлснөөр Санхүүгийн Зохицуулах Хороо болон харилцагч байгууллага, иргэд, хувьцаа эзэмшигчиддээ маш ойлгомжтойгоор өөрийн эрсдэлийн үнэлгээгээ тайлагнан ажиллаж байна.



# Эрсдэлийн матриц



Хэвийн

1-4



Байнга хяналт  
тавих

5-20



Өөрчлөлт  
сайжруулалт хийх

21-50



Тусгай зөвшөөрлийг  
түдгэлзүүлэх

51-с ▲

## Анхаарал тавих түвшин

Зах Зээлийн Нөлөөллийн Индекс	Бага	Дунд ▼	Дунд ▲	Өндөр	Маш өндөр
Учирч Болох Эрсдэл Индекс					
Бага	Green	Green	Green	Light Green	Light Green
Дунд ▼	Green	Green with white triangle ▲	Light Green	Light Green	Orange
Дунд ▲	Green	Light Green	Light Green	Orange	Red
Өндөр	Green	Light Green	Orange	Red	Red
Маш өндөр	Light Green	Light Green	Orange	Red	Red

Ерөнхий үнэлгээ	Бага	Дунд ▼	Дунд ▲	Өндөр	Маш өндөр
Нийт эрсдэл	Green	Light Green with white triangle ▲	Light Orange	Orange	Red
Удирдлага Хяналтын Орчны үнэлгээ	Green	Light Green with white triangle ▲	Light Orange	Orange	Red
Санхүүгийн Шинжилгээний үнэлгээ	Green	Light Green	Light Orange with red triangle ▲	Orange	Red
Зах Зээлийн Нөлөөллийн үнэлгээ	Green	Light Green with white triangle ▲	Light Orange	Orange	Red



АУДИТААР БАТАЛГААЖСАН  
САНХҮҮГИЙН ТАЙЛАН



“АМАР ДААТГАЛ” ХХК-ИЙН  
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДЭД  
ТАНАА

## “БЭСТ ФОРТУНА АУДИТ” ХХК

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 2-р хороо  
“Урбанск” ХХК-ийн байр 306, 307 тоот  
Утас: 324338, 89116465, 98056465, 99095580  
И-мэйл: fortune2009audit@gmail.com

2026. 03. 12 № 42

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

#### **Зөрчилгүй дүгнэлт**

Бид “Амар даатгал” ХХК-ийн 2025 оны 12 сарын 31-нээрх Санхүүгийн байдлын тайлан, энэ өдрөөр тасалбар болсон Орлогын дэлгэрэнгүй, Өмчийн өөрчлөлт, Мөнгөн гүйлгээний тайлангууд болон эдгээр тайлантай холбоотой нэмэлт тайлбар тодруулга болон Нягтлан бодох бүртгэлийн бодлогуудад аудит хийж гүйцэтгэлээ.

Бидний дүгнэлтээр Санхүүгийн тайлангуудыг бэлтгэхдээ СТОУС, түүнд нийцүүлэн гаргасан Монгол Улсын Сангийн сайдын тушаалаар батлагдсан нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой журам, зааврын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, бодитойгоор илэрхийлсэн байна.

#### **Дүгнэлтийн үндэслэл**

Аудитын явцад нягтлан бодох бүртгэлийн хувьд баримталсан зарчим, сонгож хэрэглэсэн арга, дотоод хяналтын системийг судлав. Санхүүгийн тайлангууд нь материаллаг алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэл бүхий нотолгоо олж авах зорилгоор аудитын түүврийн болон бусад арга горимуудыг гүйцэтгэсэн бөгөөд бидний гүйцэтгэсэн аудит нь аудитын дүгнэлт гаргахад хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоогоор хангагдсан гэж итгэж байна.

#### **Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь аудиторын мэргэжлийн шийдлийн хүрээнд тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлсэн асуудлууд байдаг. Эдгээр асуудлыг бид санхүүгийн тайлангийн аудитын агуулгын хүрээнд бүхэлд нь болон энэ тайлангийн талаар аудиторын дүгнэлт гаргахад авч үзсэн бөгөөд аудитор эдгээр асуудлаар тусад нь дүгнэлт өгдөггүй.

#### **Бусад мэдээлэл**

Удирдлага нь бусад мэдээллийн хувьд үүрэг, хариуцлага хүлээнэ. Бусад мэдээлэл гэдэгт санхүүгийн тайланд орсон мэдээллийг хамруулж ойлгох ба санхүүгийн тайланд өгсөн

бидний дүгнэлт нь бусад мэдээллийг хамрахгүй бөгөөд үүнд бид ямар нэгэн баталгаажуулалт илэрхийлэхгүй.

**Санхүүгийн тайлангийн талаар удирдлагын болон засаглал хариуцсан этгээдүүдийн хүлээх үүрэг хариуцлага**

Удирдлага нь Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн дагуу эдгээр санхүүгийн тайланг бэлтгэх, үнэн зөв толилуулах хариуцлага хүлээх бөгөөд мөн залилан юмуу алдаанаас үүдэлтэй материаллаг алдаа зөрчилгүй бэлтгэж, нягтлан бодох бүртгэлийн тохиромжтой бодлогуудыг сонгож хэрэглэх, шударгаар толилуулахтай холбоотой, зайлшгүй чухал гэж өөрийн тодорхойлсон дотоод хяналтуудын талаарх хариуцлагыг хүлээнэ. Засаглал хариуцсан этгээдүүд санхүүгийн тайлагналын үйл явцыг хянах үүрэгтэй.

**Аудиторын хүлээх үүрэг хариуцлага**

Бидний зорилго бол ёс зүйн шаардлагуудыг дагаж мөрдөн, санхүүгийн тайлангууд бүхэлдээ аливаа залилан эсвэл алдаанаас үүдэлтэй материаллаг хэмжээний буруу илэрхийлэлгүй эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах болон бидний дүгнэлтийг багтаасан аудиторын тайлан бэлтгэх юм. Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь өндөр түвшний баталгаажуулалт боловч Аудитын олон улсын стандартын дагуу гүйцэтгэгдсэн аудитаар оршин байгаа материаллаг буруу илэрхийллийг үргэлж илрүүлнэ гэсэн баталгаа өгдөггүй. Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас гарах бөгөөд хэрэв тэдгээр нь дангаараа болон нийлбэр дүнгээрээ санхүүгийн тайлангуудад үндэслэн хэрэглэгчдийн гаргах эдийн засгийн шийдвэрт мэдэгдэхүйц нөлөөлөх бол материаллаг гэж үзнэ.

ЗАХИРАЛ  Ж. ОЮУНЦЭЦЭГ



## Санхүүгийн голлох үзүүлэлт

## Санхүүгийн голлох үзүүлэлтүүд

## Тэнцлийн тайлан

ҮЗҮҮЛЭЛТ	2025.12.31	2024.12.31
<b>ХӨРӨНГӨ</b>	<b>MNT'000</b>	<b>MNT'000</b>
Бэлэн мөнгө	99,369	94,609
Харилцах	2,004,014	1,232,153
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн дүн</b>	<b>2,103,382</b>	<b>1,326,762</b>
Даатгалын хураамжийн авлага (цэвэр дүнгээр)	2,328,095	3,777,473
Буруутай этгээдээс авах авлага (цэвэр дүнгээр)	399,857	327,885
Давхар даатгалаас авах авлага (цэвэр дүнгээр)	20,606	3,089
<b>Даатгалын авлагын дүн</b>	<b>2,748,558</b>	<b>4,108,447</b>
Бусад санхүүгийн хөрөнгийн дүн	541,565	309,248
Бусад санхүүгийн бус хөрөнгийн дүн	1,084,162	473,029
Хадгаламж, хадгаламжийн сертификат	11,388,097	9,617,026
Үнэт цаас (цэвэр дүнгээр)	9,961,023	9,308,566
<b>Хөрөнгө оруулалтын дүн</b>	<b>21,349,121</b>	<b>18,925,592</b>
ДД-ын хойшлогдсон хураамж	740,214	3,519,426
Нөхөн төлбөрийн нөөцийн ДД-ын ногдох хэсэг	20,853	521
Даатгалын орлогын шимтгэлийн хойшлогдсон зардал	1,754,120	1,626,621
<b>Даатгалын хөрөнгийн дүн</b>	<b>2,515,187</b>	<b>5,146,568</b>
<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>30,791,722</b>	<b>30,671,804</b>
<b>ӨР ТӨЛБӨР</b>		
Даатгалын хураамжийн буцаалтын өглөг	51,741	12,571
Даатгалын гэрээний шимтгэлийн өглөг	251,396	307,489
Давхар даатгалын өглөг	963,576	2,392,665
<b>Даатгалын өглөгийн дүн</b>	<b>1,266,713</b>	<b>2,712,725</b>
Бусад санхүүгийн өр төлбөрийн дүн	274,783	226,499
Бусад санхүүгийн бус өр төлбөрийн дүн	816,596	373,994
Орлогод тооцоогүй хураамжийн нөөц	9,382,567	11,670,863
Нөхөн төлбөрийн нөөц сангийн дүн	3,320,134	3,342,214
<b>НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН</b>	<b>15,060,792</b>	<b>18,326,294</b>

Эзэмшигчдийн өмч	5,000,000	5,000,000
Хуримтлагдсан ашиг/ (алдагдал)	10,685,116	7,345,510
<b>ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>	<b>15,685,116</b>	<b>12,345,510</b>
<b>НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>	<b>30,791,722</b>	<b>30,671,804</b>

### Орлого үр дүнгийн тайлан

ҮЗҮҮЛЭЛТ	2025.12.31	2024.12.31
	MNT'000	MNT'000
Нийт орлого	24,947,119	26,544,083
Цэвэр орлого	20,587,863	16,099,024
<b>Орлогод тооцсон хураамж</b>	<b>20,096,947</b>	<b>13,751,143</b>
Нийт нөхөн төлбөр	-7,622,267	-5,399,305
Цэвэр нөхөн төлбөр	-7,454,177	-5,066,325
<b>Зардал тооцсон нөхөн төлбөр</b>	<b>-7,411,764</b>	<b>-6,155,563</b>
Даатгалын гэрээний зардал	-4,563,259	-3,388,218
Хөрөнгө оруулалтын олз, гарз	3,429,756	2,742,277
<b>Даатгалын үйл ажиллагааны ашиг (алдагдал)</b>	<b>11,553,982</b>	<b>7,343,393</b>
Ерөнхий ба удирдлагын зардал	-5,170,676	-3,460,871
Бусад зардал	-260,676	-333,200
<b>Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)</b>	<b>-5,307,764</b>	<b>-3,612,930</b>
Орлогын албан татварын зардал	610,312	366,329
Татварын дараах ашиг (алдагдал)	<b>5,635,906</b>	<b>3,364,134</b>

ҮЗҮҮЛЭЛТ	2025.12.31	2024.12.31	ӨСӨЛТ/(БУУРАЛТ)
	MNT'000	MNT'000	
Нийт хураамжийн орлого	24,947,119	26,544,083	-6%
Нийт нөхөн төлбөр	7,622,267	5,399,305	41%
Даатгалын гэрээний зардал	4,563,259	3,388,218	35%
Хөрөнгө оруулалтын орлого	3,429,756	2,742,277	25%
Даатгалын үйл ажиллагааны ашиг	11,553,982	7,343,393	57%
Татварын өмнөх ашиг	6,246,217	3,730,462	67%
Цэвэр ашиг	5,635,906	3,364,134	68%
Хөрөнгө оруулалтын багц	21,349,121	18,925,592	13%
Даатгалын нөөц сан	12,702,701	15,013,077	-15%
Эздийн өмч	15,685,116	12,345,510	27%
Нийт хөрөнгө	30,791,722	30,671,804	0.4%
Хохирлын харьцаа	36%	37%	-3%
Гэрээний зардлын харьцаа	24%	24%	0%
Үйл ажиллагааны зардлын харьцаа	31%	28%	11%
<b>Хосолсон харьцаа</b>	<b>91%</b>	<b>89%</b>	<b>2%</b>
Өөрийн хөрөнгийн хүрэлцээт байдал	287%	222%	65%
Өөрийн хөрөнгийн өгөөж (ROE)	36%	67%	-31%
Хөрөнгө оруулалтын өгөөж (ROI)	16%	18%	-2%





© 2025  
Амар Даатгал төв оффис  
Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо,  
Энхтайваны өргөн чөлөө, Блю Скай Тауэр, 20-р давхар